



ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ ЖУРАМ

2025.02.28

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Чойбалсан хотын ерөнхий төлөвлөлттэй уялдуулан компанийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжийг холбох асуудлыг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журмыг тусгай зөвшөөрөл эзэмшигч дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгогч "Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем" ТӨХК болон техникийн нөхцөл хүсэгч иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

1.3. Иргэн, хуулийн этгээдийн дулааны тоног төхөөрөмж, шугамыг дамжуулах, түгээх сүлжээнд холбох эрх бүхий байгууллагын шийдвэр нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн олгосон техникийн нөхцөл байна.

1.4. Дулаан түгээх шугам сүлжээг барихад гаргасан хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэн уг шугам сүлжээний эзэмшлийн заагийг өмчийн харъяаллаар тогтооно.

1.5. Үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч, хангагч, хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн дулааны шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалтыг бүрэн хариуцаж, үзлэг үйлчилгээ, засвар шинэчлэлийг өөрийн хөрөнгөөр мэргэжлийн байгууллага, ажилтнаар гүйцэтгүүлнэ.

Хоёр. Техникийн нөхцөл олгох үндэслэл

2.1. Иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжид дулаан авах, өргөтгөл шинэчлэл хийх, ачааллыг нэмэгдүүлэх, дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээ, халаалтын системийн техникийн шийдлийг өөрчлөх, технологийн шинэчлэл хийх тухай бүрд иргэн, хуулийн этгээд нь техникийн нөхцөл авна.

2.2. Дулааны эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээний техникийн боломжгүй нэвтрүүлэх чадвар хүрэхгүй төв, салаа, салбар шугамын гидравлик тооцоог үндэслэн дулаан хэрэглэх техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохоос татгалзана. Техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хүлээн авсанаас хойш 7 хоногийн дотор судалж техникийн нөхцөл олгохоос татгалзсан хариуг өгнө.

2.3. Техникийн нөхцөлийг боловсруулахдаа Эрчим хүчний тухай хуулийн 30.1.10-т "түгээх, зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбоулах" гэсэн заалтын дагуу иргэн, хуулийн этгээдийн өмчлөлийн шугам, тоног төхөөрөмжөөр дамжуулан объектыг холбох тохиолдол бүрт дулааны техникийн нөхцөл хүсэгч нь (гэрээ, тодорхойлолт, албан бичиг) зөвшөөрөл авч баталгаажуулсан байна.

2.4. Техникийн нөхцөл хүсэж буй иргэн, хуулийн этгээд нь дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

2.4.1. Албан бичиг (аж ахуйн нэгж, албан байгуулга), өргөдөл (иргэн)

2.4.2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, эсвэл лавлагаа

- 2.4.3. Иргэний үнэмлэхний хуулбар (иргэн), эсвэл лавлагаа
- 2.4.4. Газрын гэрчилгээний хуулбар (иргэн, аан, байгууллага), эсвэл лавлагаа
- 2.4.5. Газрын кадастрын зураг (иргэн, аж ахуйн нэгж, байгууллага)
- 2.4.6. Засаг даргын "Барилгын байршил тогтоож, газар ашиглуулах эрх олгох" тухай захирамж, шийдвэр (аж ахуйн нэгж, байгууллага)
- 2.4.7. Барилгын байршлын схем, зураглал (иргэн, аж ахуйн нэгж, байгууллага)
- 2.4.8. Дулааны ачаалал, тоо хэмжээ хэрэглээг тооцсон тодорхойлолт (иргэн, аж ахуйн нэгж, байгууллага)
- 2.4.9. Тодруулах хуудас. (Нэгдүгээр хавсралт)

Гурав. Техникийн нөхцөл олголт

3.1. Техникийн нөхцөл олгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, гүйцэтгэх захирлын тушаалаар томилно. Үүнд:

1. Ажлын хэсгийн дарга Ерөнхий инженер
2. Гишүүн ЭХБХ-ийн Дулааны борлуулалтын инженер
3. Гишүүн ХААХ-ийн ХАБ-ын инженер
4. Гишүүн Дулааны шугам сүлжээний цехийн дарга
5. Гишүүн ХХ хуулийн мэргэжилтэн

3.2. Техникийн нөхцөл хүсэгчээс ирүүлсэн барилга, объектын дулааны ачаалал, байршил, шугам сүлжээнд холбох хүсэлт болон эзэмшлийн зааг зэргийг газар дээр нь судалж, Чойбалсан хотын дулаан хангамжийн хэтийн төлөв, инженерийн тооцоо судалгаанд үндэслэн иж бүрдэл техник-технологийн дүгнэлтийг ажлын хэсэг гаргана.

3.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Эрчим хүч борлуулалтын хэлтсийн хүлээн авах ажилтнаас дулааны техникийн нөхцөл хүссэн тодруулах хуудсыг авч үнэн зөв мэдээллийг оруулах, энэхүү журмын 2.4-т заасны дагуу холбогдох материалыг бүрдүүлж өгөх.

3.4. Техникийн нөхцөл хүсэгчийн бичиг баримт шаардлагыг хангаагүй, дутуу, мэдээллийн зөрүүтэй тохиолдолд хэрэглэгч хүлээн авах ажилтан тухайн өргөдлийг хүлээж авахаас татгалзан зохих зөвлөгөөг өгч буцаана.

3.5. Дулааны техникийн нөхцөл хүсэгчийн материалыг Эрчим хүч борлуулалтын хэлтэсийн дарга болон бусад холбогдох ажилтнаар дамжуулж, захирлын туслахад өгөх ба захирлын туслах хүлээн авч гүйцэтгэх захиралд танилцуулан цохолт хийлгэж, холбогдох ажилтанд нэн даруй дамжуулан өгнө.

3.6. Цохолттой дулааны техникийн нөхцлийг хэрэглэгч хүлээн авах ажилтан бүртгэлжүүлж, Дулааны шугам сүлжээ цехийн инженер, даргад шилжүүлж гарын үсэг болон хугацаатайгаар бүртгэл хийнэ.

3.7. ДШС-ний цехийн дарга нь хурал эхлэхийн өмнө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын техникийн нөхцөл хүссэн өргөдөл, бусад материалуудыг судалж, ажлын хэсгээр хэлэлцүүлэхээр бэлтгэсэн байна.

3.8. Техникийн нөхцөл олгох ажлын хэсэг нь сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн баасан гарагийн 14.00 цагт ажлын хэсгийн даргын өрөөнд техникийн нөхцөл олгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Ажлын хэсгийн даргын шийдвэрээр хуваарьт бүс өдөр хуралдаж болно.

3.9 Ажлын хэсгийн хурлаар шийдвэрлэгдэж батлагдсан дулааны техникийн нөхцлийг Эрчим хүч борлуулалтын хэлтсийн хэрэглэгч хүлээн авах ажилтанд өгөх, ХХАТ-ын ажилтан хүлээн авч шийдвэрлэсэн эсэхээр бүртгэж, хэрэглэгчид хариу өгнө.

3.10. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын техникийн нөхцөл олгохыг хүссэн өргөдөл, албан бичиг, тодруулах хуудсыг хүлээж авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн хугацаанд шийдвэрлэнэ. Ажлын хэсгийн хэмжээ болон шаардлагатай мэдээлэл авах, бүрдүүлэлт нэмж хийх шалтгаанаар техникийн нөхцлийн шийдвэрлэлтийн хугацаа хойшилж болно.

3.11. Техникийн нөхцөл авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эрчим хүчний үлдэгдэлтэй бол Эрчим хүч борлуулалтын хэлтсийн даргын шийдвэрээр төлбөрийг барагдуулах хүртэл техникийн нөхцлийн дагуу шинэ холболт хийхээс түр хугацаагаар татгалзаж болно.

3.12. Техникийн нөхцөл нь дараах хоёр хэлбэртэй байж болно. Үүнд:

1) Дулааны өндөр ачаалал бүхий томоохон цогцолбор объектын барилга угсралтын үеийн дулааны эрчим хүчний хэрэглээг хангах түр техникийн нөхцөл. Түр техникийн нөхцөлийг 9-р сарын 15-наас дараа жилийн 5-р сарын 01 хүртэл өгөх ба энэ хугацаанд Эрчим хүч борлуулалтын хэлтэстэй дулаан авах түр гэрээ байгуулна.

2) Объект бүрэн ашиглалтанд орсны дараах дулааны хэрэглээг хангах байнгын техникийн нөхцөл.

3.13. Объектын хүчин чадал, барилга, угсралт гүйцэтгэх ажлын тоо хэмжээ зэргээс хамааран техникийн нөхцөл нь 6 сараас 2 жилийн хугацаатай байна.

3.14. Иргэн, аж ахуйн нэгжийн барилга, объект нь техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд ашиглалтанд ороогүй бол хугацаа дуусахаас 1 сарын өмнө техникийн нөхцөл олгогчид хүсэлтээ гарган 1 жил хүртэл сунгуулж болно.

3.15. Засгийн газрын 2020 оны 97-р тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"-ийн зарим заалтуудаас:

2.2. "Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг дор дурдсан нөхцөл, хэмжээг баримтлан тогтооно.

1) Дулаан дамжуулах төвөөс тал бүр тийш 5м

2) Газар дээр ил байрласан шугамаас хоёр тийш 3м

3) Газар дор байрласан шугамаас хоёр тийш 5м

2.4-т Аймаг нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрчим хүчний шугам сүлжээ эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлт, эрчим хүчний шугам сүлжээний зурвасын зураглалыг үндэслэн Эрчим хүчний тухай хуулийн 33.2-т заасны дагуу хамгаалалтын зурвасыг тогтооно.

2.6-д "Хамгаалалтын зурвас дотор барилга байгууламж, орон сууц, гэр, хашаа барих, шугам сүлжээ эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно".

2.7-д "Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт эрчим хүчний шугам сүлжээ барьж байгуулах зайлшгүй шаардлага гарвал түүний улмаас үүдэн гарах бүхий л зардлыг шугам сүлжээг бариулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага хариуцна".

3.16. Техникийн нөхцөлийг үндэслэл муутай олгосноос учирсан хохирлыг энэ дүрмийн 3.1-т заасан уг техникийн нөхцөлийг олгосон этгээд хариуцна.

Дөрөв. Техникийн нөхцлийн агуулга

4.1. Иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгоходоо "Эрчим хүчний тухай хууль", "Дулааны эрчим хүчний хэрэглэх дүрэм", "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм", "Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм" зэрэг дүрэм, журмыг үндэс болгон Монгол улсын стандартын шаардлагыг хангасан тоног төхөөрөмжийг суурилуулсан байхаар техникийн нөхцөлд зааж өгнө.

4.2. Техникийн нөхцөлд дараах асуудлыг тусгана. Үүнд:

4.2.1. Техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг

4.2.2. Дулааны эрчим хүчний суурилагдсан хүчин чадал, хэрэглээ

4.2.3. Холболт хийх цэг (магистраль шугам, дулааны худаг, үл хөдлөх тулгуур), уг цэг дээрхи түрэлт, шугамын статик болон буцах шугамын даралт, тооцоот температур;

4.2.4. Холболтын схем (эзэмшлийн заагийг тодорхой тусгасан байх);

4.2.5. Объектыг шинээр холбосноос болон хэрэглэгч хэрэглээгээ нэмэгдүүлсэнтэй холбогдуулан дулааны шугам, худаг, зангилаа бусад тоног төхөөрөмжүүдийн өргөтгөл хийх эсэх;

4.2.6. Дулааныг хэмжих хэрэгсэл, чанарын үзүүлэлтүүдийг тогтворжуулах төхөөрөмж, тоолуур, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага

4.2.7. Объектод тавигдах тусгай шаардлага; Хэрэглэгчийн дулааны тоног төхөөрөмжинд тавих тусгай шаардлага (хими, ус цэвэрлэгээний төхөөрөмж, даралт, температур тохируулах төхөөрөмж, нөөц цахилгааны эх үүсвэр болон цахилгааны хоёр талын тэжээлтэй, нөөц тоног төхөөрөмж суурилуулах гэх мэт)

4.2.8. Объектын ашиглалт, аюулгүй ажиллагааг хангах шаардлага, дагаж мөрдөх хууль, дүрэм, журам

4.2.9. Иргэн хуулийн этгээд нь объектыг барих явцад дулаан авах шаардлага гарвал түр холболт хийх цаг, хугацааг тодорхойлсон байх;

4.2.10. Орчны тохижилтыг нөхөн сэргээх талаар авах арга хэмжээ;

4.2.11. Техникийн нөхцөлийн хугацаа;

Тав. Объектыг түгээх сүлжээнд холбох үйл ажиллагаа

5.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь баригдах барилга, объектынхоо дулааны шугам, тоног төхөөрөмжийн угсралтын зураг-төслийг барилга угсралтын ажил эхлэхээс 1 сараас доошгүй хугацааны өмнө "ДБЭХС" ТӨХК-иар заавал хянуулж баталгаажуулалт хийлгэсэн байна.

5.2. Дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, зураг төсөл, техникийн нөхцөлийн шаардлага бүрэн хангагдсан нөхцөлд шинээр барьсан буюу өргөтгөл, шинэчлэл хийсэн барилга байгууламжийг дулааны шугам сүлжээнд холбоно.

5.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дор дурьдсан бичиг баримтыг бүрдүүлж, шинэ холболт хийлгэх хүсэлтээ компанийн захиргаанд гаргасны дагуу "ДБЭХС" ТӨХК ДШС-ний цех гүйцэтгэнэ. Үүнд:

5.3.1. Дулааны шугам, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг хэсэгчлэн буюу бүрэн хүлээн авсан акт, далд ажлын актууд, гагнуурын ажлын акт, техникийн паспорт, ашиглалтын заавар болон холбогдох бусад бичиг баримтууд;

5.3.2. Шалгаж баталгаажуулсан хянах, хэмжих хэрэгсэл, автомат тохируулагчийг зураг төслийн дагуу угсарсан акт, бичиг баримтууд;

5.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь дулааны шугам хоолой, хаалт арматур, тоног төхөөрөмжийг, стандартын шаардлагыг хангасан, үйлдвэрийн сертификат, тохиролын гэрчилгээ бүхий материалаар угсарна. Хэрэв стандартын бус хуучин хоолой, хаалт арматур ашигласан бол дүүргэлт, усан шахалт хийхээс татгалзана.

5.5. ДБЭХС ТӨХК-ний ДШС-ний цех нь хэрэглэгчэй хамтран шинэ холболтын дараах усан шахалтыг ажлын даралтаар хийж, техникийн акт протоколыг үйлдэн Эрчим хүч борлуулалтын хэлтэстэй дулааны эрчим хүчээр хангах гэрээ байгуулах зөвшөөрлийг олгоно.

5.6. Аж ахуйн нэгж, байгууллага шинээр тавих дулааны тоолуурыг зөвхөн Дулааны шугам сүлжээний цехтэй гэрээ байгуулан суурилуулна.

5.7. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь дулааны шугам, тоног төхөөрөмжийн угсралтын ажлын гүйцэтгэлийн зургийн нэг хувийг техникийн нөхцөл олгогчид өгнө.

5.8. Хэрэв хэрэглэгчийн угсралтын ажилд зөрчил доголдол илэрвэл нэг сарын хугацаанд залруулах ба 10 дугаар сарын 1-ээс хойш "ДБЭХС" ТӨХК төв магистраль шугамд шинэ холболт хийхгүй.

5.9. Дулааны төв шугамд жил бүрийн 5 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 01-ний хооронд техникийн нөхцөлийн дагуу объектыг дулааны сүлжээнд холбоно.

5.10. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь дулааны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, барилга, объектын шугам хоолой, хаалт арматур, тоног төхөөрөмжийн засвар, угсралтын ажлыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1. Дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл авахдаа үйлчилгээний хураамжийн 0.05-0.5 Гкал/цаг хүртэл ачаалалтай бол 40,000 (дөчин мянган) төгрөгийг иргэн,

Дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл авахдаа үйлчилгээний хураамжийн 0.5-1.0 Гкал/цаг хүртэл ачаалалтай бол 80,000 (наян мянган) төгрөгийг иргэн,

Дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл авахдаа үйлчилгээний хураамжийн 0.05-1.0 Гкал/цаг хүртэл ачаалалтай бол 250,000 (хоёр зуун тавин мянган) төгрөгийг хуулийн этгээд Эрчим хүч борлуулалтын хэлтсийн орлогын кассанд тушаана.

Дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл авахдаа үйлчилгээний хураамжийн 1.0 Гкал/цаг дээш ачаалалтай бол эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 500,000 (дөрвөн зуун мянган) төгрөгийг хуулийн этгээд тушаана.

6.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь объектоо дулааны сүлжээнд холбох үед гарах зардлыг өөрөө хариуцна.

6.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дулааны шугам сүлжээ нь газар доорхи инженерийн шугам сүлжээг дайрах, зам талбай бут сөөг, зүлэг модыг эвдэж гэмтээх тохиолдолд тэдгээрийг нөхөн сэргээхэд гарах зардлыг өөрөө хариуцна.

6.4. "ДБЭХС" ТӨХК нь техникийн нөхцөл олгосон иргэн аж ахуйн нэгж байгууллагатай хамт эзэмшлийн заагийг тодорхойлно.

6.5. Техникийн нөхцөлийн дагуу иргэн хуулийн этгээдийн объектыг дулааны шугам сүлжээнд холбоход Дулаан хуваарилах төвийн (ДХТ) хүчин чадлыг болон төв магистраль шугам, салаа шугам сүлжээг зайлшгүй өргөтгөх шаардлагатай бол холбогдох зардлыг иргэн, хуулийн этгээд өөрөө хариуцна.

6.6. Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.9, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус мөрдөж өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбоулах, өөрийн шугамаас хэрэглэгч холбох үйл ажиллагаанаас ашиг олох зорилгоор бизнес үйл ажиллагаа явуулахгүй байх.

6.7. Техникийн нөхцлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно. Үүнд:

6.7.1. Техникийн нөхцөл авахын тулд дулааны эрчим хүчний хэрэглээний өгөгдлүүдээ зориуд буруу тодорхойлсон нь тогтоогдсон бол;

6.7.2. Холболт хийх цэгийн хүчин чадлаас хэтрүүлэн техникийн нөхцөл олгосон бол;

6.7.3. Техникийн нөхцөлийн хүчинтэй байх хугацаанд тухайн объект дулааны сүлжээнд холбогдоогүй бол;

6.7.4. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгуулах хүсэлтийг "ДБЭХС" ТӨХК-д гаргаагүй бол;

6.8. Хугацаа дууссан техникийн нөхцлөөр зураг төсөл боловсруулах барилга байгууламж барихыг хориглоно.

6.9. Техникийн нөхцөлтэй холбоотой гарсан маргааныг хууль, дүрэм, журмын дагуу шийднэ.

6.10. Энэхүү журмыг 2025 оны 03 дугаар сарын 01 ны өдрөөс эхлэн мөрдөнө.

ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

ЭХБХ-ИЙН ДУЛААНЫ ИНЖЕНЕР

ХАБ-ЫН ИНЖЕНЕР

ЗХНХ-ИЙН ХХХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН.

ДШС-НИЙ ЦЕХИЙН ДАРГА

Я. НАРАНБААТАР

Т. ЭНХБОЛОРМАА

Г. ЭНХБАЯР

Н. ОДГЭРЭЛ

Ж. ГАНТУЛГА

Дулааны эрчим хүчээр хангах техникийн
нөхцөл олгох журмын нэгдүгээр хавсралт

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН
НӨХЦӨЛ ОЛГОХ ТОДРУУЛАХ ХУУДАС

Дугаар №.....

Огноо

Хэрлэн сум

1. Техникийн нөхцөл авахаар хүсэлт гаргаж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэний
Нэр
2. Хэрэглэгчийн утасны дугаар:
3. Техникийн нөхцөл авах объектын байршил, хаягийн тодорхойлолт:
Хаяг: хэрлэн сум баг, гудамж тоот
4. Объектийн хэмжээ: талбай m^2 , эзлэхүүн m^3
4. Техникийн нөхцөл авах объектын дулааны тооцоот ачаалал:
халаалт Гкал/ц
хэрэгцээний халуун ус Гкал/ц
салхивч Гкал/ц
5. Техникийн нөхцөл авах болсон шалтгаан:
6. Хэрэглэгчийн ажлын горим:
7. Хэрэглэгчийн зэрэглэл:
8. Орон нутгийн засаг захиргааны газар олголтын тогтоолын:
Дугаар огноо
9. Эрчим хүчний төлбөрийн үлдэгдэлтэй эсэх
..... (авлага барагдуулах хэсэг)

Жич Тодруулах хуудас дээрх өгөгдлүүдийг үнэн зөв бичих, буруу бичсэнээс гарах хохирлыг хэрэглэгч өөрөө
хариуцна

ТОДРУУЛАХ ХУУДАС БИЧСЭН: / /

МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВСАН АЖИЛТАН:
.....
.....
.....

202.....

огноо